



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2021 оны 05 сарын 20 өдөр

Дугаар 84

Мандалговь

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь заалт, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021 оны 84 дүгээр тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.2, 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Сайнцагаан суманд барьж ашиглалтад оруулсан нийт 1,538,731,954 /Нэг тэрбум таван зуун гучин найман сая долоон зуун гучин нэгэн мянга есөн зуун тавин дөрөв/ төгрөгийн өртөг бүхий барилга, эд хөрөнгийг Сайнцагаан сумын 1 дүгээр цэцэрлэгийн үндсэн хөрөнгийн дансанд хавсралтын дагуу бүртгэхийг зөвшөөрсүгэй.

Хоёр: Сайнцагаан сумын 1 дүгээр цэцэрлэгийн эрхлэгчийн үүргийг түр орон гүйцэтгэгч (Б.Бямбаа)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

- 2.1. Комисс томилон хөрөнгө хүлээн авч бүртгэх ажлыг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;
- 2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;
- 2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2021 оны 2 дугаар улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх;

Гурав: Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.ОД-ЭРДЭНЭ



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2021 оны 05 дугаар сарын
20-ний өдрийн 87-тогтоолын хавсралт

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон
1-р цэцэрлэгийн үндсэн хөрөнгөд бүртгэх хөрөнгийн жагсаалт

№	Хөрөнгийн нэр	Хэмжих нэгж	Нэгжийн үнэ	Тоо ширхэг	Нийт үнэ
Барилга байгууламж					
1	Барилга	ш	1 532 321 954	1	1 532 321 954
Барилга байгууламжийн дүн					1,532,321,954
Тоног төхөөрөмж					
1	Хүлээн авах станц	Ш	700 000	1	700 000
2	Камерын дэлгэц	ш	500 000	1	500 000
3	Видео дуран	ш	280 000	12	3 360 000
4	Үүдний тенг	ш	350 000	1	350 000
5	Насос / Бойлоор /	ш	1 500 000	1	1 500 000
Тоног төхөөрөмжийн дүн					6,410,000
Нийт дүн					1,538,731,954 /нэг тэрбум таван зуун гучин найман сая долоон зуун гучин нэгэн мянга есөн зуун тавин дөрөв/